



2026 ОНЫ I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ГАРЧИГ**НЭГ. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА**

1.1	Компанийн танилцуулга	2
1.2	Тусгай зөвшөөрөл, лиценз	2
1.3	Компанийн бүтэц, нийт ажилтны тоон мэдээлэл	4

ХОЁР. ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙН БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1	ХЭМАБ-н зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа	4
2.2	ХЭМАБ-н хүн хүч, хүн цаг, сургалт болон өдөр тутмын зааварчилгааны зөрчлийн тоо	5
2.3	Аюултай нөхцөл байдал, асгаралтын зөрчил, үйлдвэрлэлийн ослын тоо	6
2.4	Дотоод хяналт болон ажлын байрны үзлэгээр илэрсэн үл тохирлыг залруулсан байдлын хэрэгжилт	8
2.5	ХЭМАБ-н дадал, хэвшил	12

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ БА БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал	13
3.2	Байгууллагын соёлын үнэлгээ	24

ДӨРӨВ. ИЛ УУРХАЙН БОЛОН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1	Үйлдвэрлэлийн төлөвлөгөөний биелэлт	28
4.2	Технологийн горим мөрдөж ажилласан байдал	29
4.3	Тоног төхөөрөмж, техникийн бэлэн байдлын коэффициентын биелэлт	31

ТАВ. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1	Борлуулалтын орлогын гүйцэтгэлийг батлагдсан төлөвлөгөөний биелэлт	37
5.2	Аудитлагдсан санхүүгийн тайлангийн үнэлгээ, зөвлөмж, албан шаардлагын биелэлт	39

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ

6.1	Байгаль орчны зөрчлийн үнэлгээ	42
6.2	Ус ашиглалтын тайлангийн үнэлгээ	42
6.3	Мод тарих, ойн санг нэмэгдүүлэхээр ажилласан байдал	43

ДОЛОО. ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

7.1	Төслийн үйл ажиллагааны үнэлгээ	44
-----	---------------------------------	----

НЭГ. КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Компанийн товч танилцуулга

Алсын хараа

Монгол Улсын хөгжил, эдийн засагт бодитой хувь нэмэр оруулж, хариуцлагатай уул уурхайг түүчээлсэн үлгэр жишээ компани байна. Байгаль орчинд ээлтэй уул уурхайг хөгжүүлж, эцсийн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулж, баялгийг бүтээлцэнэ. Монгол Улсын үнэт металлын хайгуул, олборлолт, үйлдвэрлэлийг Олон Улсын жишигт хүргэнэ.

Уриа үг

ЭХ ОРНЫ ЭРДЭНЭС-ИРЭЭДҮЙН БАЯЛАГ

Эрхэм зорилго

Бид тогтвортой, хариуцлагатай үйлдвэрлэлийг эрхэмлэн үндэсний баялгийг бүтээнэ. Бид Олон Улсын стандартад нийцсэн эрэл хайгуулыг хийж, алтны нөөцийг нэмэгдүүлэн, ард иргэдийнхээ эрх ашгийг дээдлэн, хууль журмын хүрээнд ажиллаж, эх орныхоо баялгийг нийтэд эрх тэгш хүртээнэ. Байгалийн баялгийн нөөц боломжийг зохистой ашиглах хүрээнд төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогыг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэн, аюулгүй, шударга, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд дэвшилтэт техник технологи, мэргэжлийн ур чадвараар манлайлан ажиллана.

Үнэт зүйлс

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Манлайлал, Инновац, Байгууллагын соёл

ЭРҮҮЛ МЭНД - Эрүүл хүн - Баялаг бүтээгч

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА - Аюулгүй ажиллагааг улам бататгаж, салбартаа тэргүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИН- Дэлхийн жишигт нийцсэн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг нэвтрүүлж, хамт олон, харилцагч, түнш, олон нийтийн болон тэдний хоорондын эрх ашгийг дээдлэн хүндэлнэ.

МАНЛАЙЛАЛ - Хамтдаа хөгжих, хөдөлмөр эрхлэлтийн тэгш нөхцөл боломжоор хангаж, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчнээр хамт олныг бүрдүүлнэ.

ИННОВАЦ - Стратегийн ач холбогдол бүхий үнэ цэнтэй, хязгаарлагдмал байгалийн баялгаар ISO стандартад нийцсэн бүтээгдэхүүнийг БИД үйлдвэрлэнэ.

БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ - Бид бие биеэ хүндэтгэн, үнэнч шударга, хариуцлагатай, ёс зүйтэй ажиллана. Бид хамтын шийдвэр гаргаж, багийн гишүүн бүрийн оролцоотойгоор ажлыг үр бүтээлтэй, цаг хугацаанд нь хийж гүйцэтгэнэ.

1.2 Тусгай зөвшөөрөл, лиценз


- Ашиглалтын тусгай зөвшөөрөл

Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн хүрээнд, Засгийн Газрын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэл, Ашигт малтмал, газрын тосны газрын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 341 дүгээр шийдвэрээр Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Салхит” нэртэй 2,887.85 га бүхий ашигт малтмал ашиглах ашиглалтын MV-021483 тоот тусгай зөвшөөрөл олгосон.

Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумд орших Овоот хяр нэртэй 1,791.44 га ашиглалтын MV-022843 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайг 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдөр олгосон.


- **Хайгуулын тусгай зөвшөөрөл**

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоолын дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Овоот хяр нэртэй XV-21670 тоот 22641,51 га талбай бүхий хайгуулын тусгай зөвшөөрөл, Өмнөговь аймгийн Цогтцэций, Манлай сумдын нутагт байрлах Өлзийт овоо нэртэй XV-021671 тоот 16634.29 га талбай бүхий тусгай зөвшөөрөл, Засгийн Газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 212 тоот тогтоол, АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших “Хүрэн цав” нэртэй хайгуулын XV-021666 тоот тусгай зөвшөөрлүүдийг тус тус олгосон.



Тусгай зөвшөөрөл	Тоо
Ашиглалтын тусгай зөвшөөрөл	2
Хайгуулын тусгай зөвшөөрөл	7
Нийт тусгай зөвшөөрөл	9

1.3 Компанийн бүтэц, нийт ажилтны тоон мэдээлэл



Нийт ажилтны тоон мэдээлэл

Үзүүлэлт	Тоон мэдээлэл
Тайлант онд батлагдсан орон тоо	145
Тайлант хугацаанд байсан нийт ажилтны тоо	128
Тайлант хугацаанд ажиллаж байгаа нийт ажилтны тоо	130
Өөрчлөлтийн хувь	1.4%
Гэрээт ажилтны тоо	-
Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй ажилтны тоо	7

ХОЁР. ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 ХЭМАБ-н зөрчлөөс шалтгаалсан сул зогсолтын хугацаа

“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн Салхит уулын баяжуулах үйлдвэр нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 226,668 хүн/цаг ажил гүйцэтгэж осол, осол дөхсөн тохиолдолгүй ажилласан.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын үзүүлэлтүүд



2.2 ХЭМАБ-н хүн хүч, хүн цаг сургалт, өдөр тутмын зааварчилгааны тоо

Салхит уулын баяжуулах үйлдвэрийн ХЭМАБ-н тоон үзүүлэлт

Хүн/хүч



Хүн/цаг



Компанийн нэрс	Хүн/хүч	Хүн/цаг	ХАБЭА-н зааварчилгаа	Сургалт (хүний тоо)
"Эрдэнэс алт ресурс" ХХК	2,077	24,924	2,696	43
"Аглаг хангайн уулс" ХХК	6,571	78,852	7,530	251
"Соёолон интернэшнл" ХХК	6,350	76,200	7,597	179
"Супер херо катеринг" ХХК	1,231	14,772	1,464	30
"Онц цэвэрлэг булаг" ХХК	960	11,520	1,101	24
"Хос жирэм" ХХК	251	3,012	290	5
"Юнайтэд бэст ойл" ХХК	82	984	1	0
"Дулаан сэнтий" ХХК	820	9,840	848	14
"Ханлаб" ХХК	377	4,524	301	12
"Эс жи эс" ХХК	45	540	0	0
Гэрээт ажил дууссан компаниудын нийт хүн/цаг	125	1,500	-	-
Нийт	18,889	226,668	21,828	558

2.3 Аюултай нөхцөл байдал, асгаралтын зөрчил, үйлдвэрлэлийн ослын тоо

Салхит уулын баяжуулах үйлдвэрийн аюулгүй байдал


Компанийн нэр	2026 оны 1-р улирал		
	Аюултай нөхцөл байдал	Асгаралтын зөрчил	Үйлдвэрлэлийн осол
"Эрдэнэс алт ресурс" ХХК	0	0	0
"Аглаг хангайн уулс" ХХК	1	0	0
"Соёолон интернэшнл" ХХК	0	0	0
"Супер херо катеринг" ХХК	0	0	0
"Онц цэвэрлэг булаг" ХХК	0	0	0
"Хос жирэм" ХХК	0	0	0
"Юнайтэд бэст ойл" ХХК	0	0	0
"Дулаан сэнтий" ХХК	0	0	0
"Ханлаб" ХХК	0	0	0
"Эс жи эс" ХХК	0	0	0
Бусад компани /түр гэрээ/	0	0	0
НИЙТ	1	0	0

Аюултай нөхцөл байдлын талаар:

"2026 оны 02 дугаар сарын 01-ний өдөр СУБҮ-ийн Баяжуулах 1 дүгээр үйлдвэрийн пресс фильтерийн дээд хэсэгт байрлах, сэндвичэн хийцтэй барилгын дээврийн урд хэсгийн үндсэн элемент болох С хэлбэрийн дам нуруу (С төмөр) нь ашиглалтын явцад зэврэлтэд орж, ачаалал даах чадвар нь буурсны улмаас хэсэгчлэн цөмөрч, нурах аюул, эрсдэл үүссэн. Уг аюултай нөхцөл байдлыг Баяжуулах 1 дүгээр үйлдвэрийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй "Аглаг хангайн уулс" ХХК нь илрүүлэн, холбогдох мэдээллийг шуурхай мэдэгдэж ажилласан."



Аюулыг устгах ажил хийгдэж байна. Ачаалал даахгүй нумарч эргэсэн С төмөр болон нэмэлтээр хажууд нь хийсэн С төмрийн харагдах байдал



Баяжуулах 1 дүгээр үйлдвэр нь 2016 онд баригдаж ашиглалтад орсон бөгөөд түүнээс хойш барилгын үндсэн хийцлэлд их засвар хийгдээгүй байна. Тус барилга нь дээврийг А нуруутай хийцээр шийдсэн боловч урд хэсэгтээ 1.4 м өндөр доголтойгоор төлөвлөгдсөн онцлогтой. Салхи шуурга болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр баяжуулах 1-р үйлдвэрийн арын бутлах хэсгээс үүсэх шороо, тоос нь салхины урсгалаар дээврийн догол хэсэгт хуримтлагдан овоорч, нэмэлт ачаалал үүсгэсэн. Үүний улмаас барилгын үндсэн хийц болох С хэлбэрийн дам нуруу (С төмөр)-д хэт ачаалал үүсэж, хэсэгчлэн цөмрөх аюул, эрсдэлтэй нөхцөл байдал бий болсон. Дээрх болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Ачаалал даах чадвар алдагдаж, нумарсан С хэлбэрийн дам нурууны хажууд нэмэлт бэхэлгээ болгон С төмөр суурилуулж хүчитгэл хийсэн.
- Ижил төрлийн хийц бүхий хэсгүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг зохион байгуулсан.
- Дээврийн догол хэсэгт хуримтлагдсан шороо, тоосны цэвэрлэгээг ашиглалтын горимд оруулж, өдөр тутмын хяналттайгаар тогтмол цэвэрлүүлэх арга хэмжээ авсан.
- Дээврийн цэвэрлэгээний ажлын үеийн аюулгүй байдлыг хангах зорилгоор босоо баганаас бэхэлгээ авч, хооронд нь троссоор холбон нийт 7 бэхэлгээний

цэг бүхий хөдөлгөөнт хамгаалалтын систем (амь олс, өндрөөс хамгаалах хэрэгсэл бэхлэх боломжтой) суурилүүлсан.

- Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлснээр дээврийн цэвэрлэгээний ажлын үеийн аюулгүй байдлыг хангаж, цаашид үүсэх эрсдэлийг бууруулсан гэж үзэж байна.

Баяжуулах 1-р үйлдвэрийн дээвэрт хийсэн 7 аюулгүй цэг, түүнийг холбосон хөдөлгөөнт бэхлэгээний тороосны хийгдсэн байдал



2.4 Дотоод хяналт болон ажлын байрны үзлэгээр илэрсэн үл тохирлыг залруулсан байдлын хэрэгжилт


Тайлант оны I улиралд ХЭМАБ-ын дотоод хяналтын журмын дагуу I болон II шатны үзлэг, шалгалтыг календарчилсан төлөвлөгөөний дагуу компанийн хэмжээнд нийт 3 удаа зохион байгуулж, үндсэн болон гэрээт компаниудын үйл ажиллагааг бүрэн хамруулан хэрэгжүүлсэн. Үзлэг, шалгалтын явцад холбогдох маягтын дагуу бүртгэл, тэмдэглэл хөтөлж, илэрсэн зөрчил, үл тохиролд өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд нийт 31 үл тохирол илрүүлсэн бөгөөд гарч болзошгүй осол, аваарын эрсдэлийг бууруулах зорилгоор уг үл тохирлуудыг бүрэн арилгаж, шаардлагатай залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж хэрэгжүүлсэн. “Илэрсэн үл тохирлын 100 хувийг хугацаанд нь арилгаснаар ажлын байрны аюулгүй байдлыг хангах, осол аваарын эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдсэн байна.”

Үл тохирлыг арилгах хугацаатай үүрэг даалгаврын хүүдасны харагдах байдал

[illegible]

[illegible]

Арилгасан үл тохирол 31 үүнээс эзлэх %



Илэрсэн үл тохирлуудыг аюулын зэргээс нь хамааруулан нэн даруй, ноцтой, дунд, бага эрсдэлийн ангиллаар ялган үнэлж, холбогдох хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд нийт 31 үл тохирол илрүүлснээс бүгдийг бүрэн арилгаж, хэрэгжилтийг ханган ажигдласан.

ХЭМАБ-ЫН ХҮРЭЭНД ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХИЙГДСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

➤ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/130 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, мөн СУБҮ-ийн ХЭМАБ-ын зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй 8 компанийн нийт 437 ажилтныг хамруулсан сургалтыг зохион байгуулж, холбогдох агуулга, сэдвийн дагуу мэдлэгийн шалгалт авч ажилласан. Тус сургалтыг гэрээт компанийн сургагч багш нар, уурхайн эмч болон ХЭМАБ-ын ажилтнууд хамтран зохион байгуулсан.

Нийт ажилчдын сургалтын сэдэв, агуулга

№	Сургалтын сэдэв	Сургалтын агуулга
1	ХАБЭА-н хууль, ерөнхий ойлголт	ХАБЭА-н тухай хууль дах ажилтны эрх үүрэг, хөдөлмөрийн тухай хууль, ажилтны эрх, үүргийн тухай ойлголт өгөх
2	Байгууллагын онцлог	СУБУ-ийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй компаниудын албан ёсны танилцуулах
3	Аюул, эрсдэл	Аюул эрсдэлийн тухай ойлголт, эрсдэлийн үнэлгээ
4	НБХХ-ийн тохироо, ач холбогдол	НБХХ-ийн тухай ойлголт, хөдөлмөрийн эрүүл мэндийн тухай ойлголт өгөх
5	Анхны тусламж	Анхны тусламж хэрхэн үзүүлэх тухай үндсэн ойлголт өгөх

6	Онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээ	Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн тухай ойлголт, гал, галын хорны тухай ойлголт өгөх
7	ҮОХХСБ Дүрэм	ҮОХХ тухай, ҮОХХ-с сэргийлэх, өртсөн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хууль эрхзүйн ойлголт, ҮОХХ-г судлан бүртгэх комисс түүний үйл ажиллагааг танилцуулах
8	Байгаль орчны асуудал ба оролцоо	Хүний эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийг хангах, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хадгалах, өнөө болон ирээдүйн үеийнхний ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхэд оролцох оролцоог нэмэгдүүлэх

Нийт ажилтнуудын сургалтад хамрагдсан байдал

№	Компанийн нэр	Нийт ажилтны тоо	Хамрагдсан хүний тоо	%	Тайлбар
1	“Эрдэнэс алт ресурс” ХХК	54	38	70%	-
2	“Аглаг хангайн уулс” ХХК	131	135	103%	Шинээр ажилд орсон ажилтнууд хамрагдсан
3	“Соёолон интернэшнл” ХХК	153	143	93%	-
4	“Онц цэвэрлэг булаг” ХХК	28	25	89%	-
5	“Дулаан сэнтэй” ХХК	21	21	100%	-
6	“Хос жирэм” ХХК	8	5	63%	-
7	“Супер херо катеринг” ХХК	30	28	93%	-
8	“Ханлаб” ХХК	12	8	67%	-
Нийт		437	403	92%	-

Сургалтын үйл явцын зураг



Тайлангийн тайлбар (нэмэлт): 2026 оны I улиралд уурхайн бүсэд үйл ажиллагаа явуулж буй 8 компанийн нийт 437 ажилтнаас 403 ажилтан сургалтад хамрагдаж, дундаж хамрагдалт 92 хувийг бүрдүүлсэн байна. Хамрагдаагүй ажилтнуудыг ажлын байрны онцлог болон ээлжийн зохицуулалттай уялдуулан дараагийн хугацаанд бүрэн хамруулахаар төлөвлөсөн.

➤ Хэт хуурайшилтын улирал эхэлж байгаатай холбогдуулан Салхит уулын баяжуулах үйлдвэрийн бүсийн барилга, байгууламжийн орчмын өнжмөл өвс, салхинд туугдан хуримтлагдсан ургамлын үлдэгдлийг тогтмол цэвэрлэж, гал түймрийн аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд гэрээт компаниудын хариуцсан талбайд цэвэрлэгээний ажлыг гүйцэтгүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажилласан бөгөөд тухай бүр тайланг хүлээн авсан болно.

➤ Салхит уулын баяжуулах үйлдвэрийн галын аюулгүй байдлыг хангах хүрээнд гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраагуур, мөн гал унтраах тусгай зориулалтын автомашины бэлэн байдлыг шалгах үзлэгийг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулан тайланг хүлээн авч ажилласан.

Галын аюулгүй байдлыг хангах ажлын үеийн зураглал



➤ Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын хавсралтын 5.1-д заасан шаардлагын дагуу Онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас жил бүрийн 03 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Пүрэв гарагт зохион байгуулдаг гамшигын аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллах дадлага, сургуулилтыг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт СУБУ-ийн бүсэд амжилттай зохион байгуулсан.

Дадлага сургуулилтад хамрагдаж байгаа байдал



Аваарын зарлан мэдээлэх дуут дохиог өгөхдөө SY-200B, LK-120 загварын 2 төрлийн нийт 3 сиренийг ашиглаж байна. Гэвч эдгээр сирений дуу нь Баяжуулах 1 болон 2 дугаар үйлдвэрийн доторх үйлдвэрлэлийн дуу чимээг даван сонсогдохгүй байгаа нь тухайн ажлын байранд ажиллаж буй ажилтнууд аваарын дохиог бүрэн хүлээн авч, зохих арга хэмжээ авах нөхцөлийг хангахгүй байна. Аваарын дохионы сонсогдох түвшин хангалтгүй байгаагаас ажилтнуудыг шуурхай мэдээллээр хангах, аюулын үед зохих хариу арга хэмжээ авах боломж хязгаарлагдаж байна.

Дүгнэлт: Гамшиг, аваар ослын үед шуурхай, үр дүнтэй зарлан мэдээлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нэгдсэн удирдлагатай зарлан мэдээллийн систем нэвтрүүлэх шаардлагатай байна. Системийг нэвтрүүлснээр аюул, ослын үед мэдээллийг цаг

алдалгүй дамжуулах, ажилтнуудыг шуурхай зохион байгуулах, улмаар үүсэх эрсдэл, хохирлыг бууруулах боломж бүрдэнэ. Мөн баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламжийн дотор талд зарлан мэдээлэх чанга яригч болон гэрлэн дохиоллын системийг суурилуулах шаардлагатай. Нэгдсэн удирдлагатай зарлан мэдээллийн систем гэдэг нь Салхит уулын баяжуулах үйлдвэрийн төв оффис, амралтын байр, уулын кемп, цахилгаан хангамжийн диспетчерийн байр, уурын зуухнууд, Баяжуулах 1, 2 дугаар үйлдвэр, үйлдвэрийн ажилчдын оффис зэрэг бүх байршлыг бүрэн хамруулсан, дуут болон гэрлэн дохиог нэг цэгээс удирдах боломжтой цогц шийдэл юм.

2.5 ХЭМАБ-н дадал, хэвшил

Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуйн сургалт, ур чадвар олгох ажлын хүрээнд:

➤ Салхит уурхайн бүсэд ажилтнуудыг эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй байдлаар ажил үүргээ гүйцэтгэх чадамжтай болгох зорилгоор ХЭМАБ-ын тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн урьдчилсан зааварчилгааны сургалтыг зохион байгуулж, нийт ажилтнуудыг бүрэн хамруулан шалгалт авч, амжилттай хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд буюу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хөдөлмөрийн аюулгүй байдлын өдөр тутмын зааварчилгаанд нийт **21,828** ажилтан, шинэ болон ажлын байраа сольсон **89** ажилтан сургалтад, зочдын зааварчилгаанд **52** иргэн, ХЭМАБ-ын сургалтад **558** ажилтан, ажлын байрны давтан зааварчилгаанд **1,569** ажилтан тус тус хамрагдсан байна.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, ур чадвар олгох үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүй, дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн зохион байгуулах;
- Сургалтын баримт бичиг, бүртгэл, хадгалалтыг холбогдох журам, стандартын дагуу бүртгэлийн сан үүсгэн хөтлөх, архивлах;
- Сургалттай холбоотой тайлан, мэдээг тогтмол боловсруулж, холбогдох нэгжүүдийг мэдээллээр хангах.

ХЭМАБ-ын сургалтыг хууль тогтоомж, холбогдох стандарт, журамд нийцүүлэн, ажилтны гүйцэтгэх ажлын онцлог, ажлын байрны тодорхойлолт, эрсдэлийн үнэлгээ болон бусад хүчин зүйлд тулгуурлан хугацаат хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, чанартай, үр дүнтэй зохион байгуулахад анхаарч ажиллаж байна. ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны шаардлага, сургалтын журмын дагуу сургалтын холбогдох материалуудыг бичвэр болон цахим хэлбэрээр баримтжуулан хадгалж, бүртгэлийн санг тогтмол шинэчлэн хөтөлж байна. Сургалтын үйл ажиллагааны тайланг долоо хоног, сар, хагас жил, жилийн эцсээр тогтмол боловсруулж, байгууллагын удирдлага болон холбогдох нэгжүүдийг мэдээллээр хангах ажлыг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ БА БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН ҮНЭЛГЭЭ

3.1 Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн байдал

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 144 дүгээр тогтоолоор “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн 2026 оны бизнес төлөвлөгөөнд шинэчлэн батлагдсан бүтэц зохион байгуулалтын дагуу Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын алба нь эрсдэл, Дотоод хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн, Эрсдэл хариуцсан мэргэжилтэн, Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн гэх 3 орон тоотойгоор эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Компанийн 2026 оны бизнес төлөвлөгөө болон хайгуул, уурхайн үйл ажиллагаатай холбоотой бий болсон, үүсэж болзошгүй эрсдэлүүдийг эрэмбэлэн тодорхойлж, үнэлэн хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан.

Эрсдэл, дотоод хяналтын албаны хүрээнд хийж хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

➤ **Зорилго 1. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг сайжруулан, соёлыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг бий болгох**

Нэгдлийн хэмжээнд бодлогын баримт, бичиг батлагдан нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжүүлэх бодлого баримтлан компаниудын холбогдох нэгж, газруудын хамаарах мэргэжилтэн, ажилтнуудыг чадавхжуулах, мэдээлэл өгөх сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж байна. Үүнийг гол хэрэгжүүлэх эрсдэл хариуцагч нарт соёлыг төлөвшүүлэн удирдлагын манлайллыг бий болгох, эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг танин мэдүүлэх, тасралтгүй сургалтыг хөгжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай байна.

➤ **Зорилго 2. Эрсдэлд суурилсан дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэн, хэрэгжүүлэх жишиг аргачлалыг төлөвшүүлэх**

Компанийн Гүйцэтгэх захирлын дэргэдэх Дотоод хяналтын албыг бүх талаар чадавхжуулан нэгдлийн хэмжээнд батлагдсан жишиг аргачлал, холбогдох хууль, журмын хүрээнд хараат бусаар ажиллах боломж, нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.

➤ **Зорилго 3. Уурхайн ХАБЭА, байгаль орчны менежментийн Олон Улсын стандартыг хангах**

Уул уурхайн үйл ажиллагаагаа бүхий үе шатуудыг хэрэгжүүлж буй компанийн хувьд үйлдвэрлэл, технологи болон ХАБЭА-н инженер, техникийн ажилтан, удирдлагуудын дагаж мөрдөх, журам зааврын шинэчлэлтийг Олон Улсын стандартад нийцсэн байхыг зайлшгүй шаардаж байна.

➤ **Зорилго 4. Төсөл, хөтөлбөрүүд, хөрөнгө оруулалтын эрсдэлийн үнэлгээнд шинжилгээ хийх**

Салхит уурхайн үйл ажиллагаа хаалтын менежментэд шилжиж бусад төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бизнесийн мөчлөгийн үед зарим техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтын эрсдэлийн үнэлгээнд шинжилгээ хийж, санал өгөх, хамтран ажиллах нь үр ашиггүй зардлыг бууруулах ач холбогдолтой юм.

➤ **Зорилго 5. Олборлох үйлдвэрлэлийн нээлттэй ил тод байдлыг ханган ажиллах, уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөнд хяналт тавих**

Төрийн өмчит компаниудад тавигддаг холбогдох хууль, журам, стандартын шаардлагыг ханган ажиллаж Засгийн Газар, толгой компанийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллах үүрэгтэй.

Нэгдлийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газраас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж байгаа бөгөөд шалгалтын үр дүн, зөвлөмжүүдийг хүлээн авч тодорхойлогдсон эрсдэлийн бүртгэл, болзошгүй магадлалыг үндэслэн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг дахин сайжруулалт хийх шаардлагатай байна.

Эрсдэлийн удирдлагын төлөвлөлийн түвшнийг Толгой компанийн боловсруулсан асуумжаар үнэлж үзэхэд **2.35** буюу үүсэж буй хоёрдугаар түвшинд байгаа нь эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг сайжруулан, соёлыг төлөвшүүлж, удирдлагын манлайллыг бий болгох зорилтын хүрээнд эрсдэл хариуцагч нарт эрсдэлийг илрүүлэх, тодорхойлох аргыг зааж, соёлыг төлөвшүүлэн удирдлагын манлайллыг бий болгох, эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг танин мэдүүлэх, тасралтгүй сургалтыг зохион байгуулах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудын хэрэгжилтийг хангуулан нээлттэй мэдээллүүдийг холбогдох цахим системд тухай бүр байршуулан ажиллаж байна.

Эрсдэлийн бүртгэл

№	Огноо	Стратегийн зорилго	Бизнес төлөвлөгөөний зорилт	Хийгдэх ажил	Эрсдэлийн ангилал	Эрсдэлийн дэд ангилал	Эрсдэл	Эрсдэлийн шалтгаан	Эрсдэлийн үр дагавар		Эрсдэлийг тодорхойлсон нэгж
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Дугаар	Эрсдэл бүртгэсэн огноо	Хамаарах стратегийн зорилго	Бизнес төлөвлөгөөний зорилт	Бизнес төлөвлөгөөний хүрээнд хийгдэх ажил	Эрсдэлийн ангилал	Эрсдэлийн дэд ангилал	Учирч болзошгүй эрсдэл	Эрсдэлийг үүсгэж байгаа хүчин зүйл (индикатор)	Санхүүгийн үр дагавар	Эрсдэл үүссэн тохиолдолд үүсэх үр дагавар	Эрсдэлийг тодорхойлсон газар, нэгж
1	2025	Санхүүгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлж ажиллана	Үйлдвэрлэлийн өртөг, ерөнхий удирдлагын зардлыг бууруулж, бүтээгдэхүүний ажиллагааг нэмэгдүүлэх	Үйлдвэрлэлийн өртгийг тодорхой хувиар бууруулах, ерөнхий зардлын орлого дахь хувийг бууруулах, ашигт ажиллагааны түвшнийг 2025 оны гүйцэтгэлээс тодорхой хувиар өсгөсөн байна	Үйл_ажиллагааны_эрсдэл	Процессын эрсдэл	Өртөг, зардал буурахгүй, өгөөж нэмэгдэхгүй байх	Төлөвлөлт, тооцооллын алдаанаас үйлдвэрлэлийн өртөг буурахгүй, хөрөнгийн өгөөж нэмэгдэхгүй байх	Төлөвлөсөн хэмжээнд орлого бүрэлдэхгүй	Орлого тасалдах, төслийн үйл ажиллагаа зогсох	Дотоод хяналтын алба
2	2025	Хүний нөөцийн тогтвортой байдал	Мэргэшсэн боловсон хүчин	Хүний нөөц бүрдүүлэлт, тогтвортой ажиллах ажлын нөхцөл бүрдүүлэх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Системийн эрсдэл	Ажиллах хүчний дутагдал	Ажлын ачаалал тэгш бус, нийгмийн асуудал шийдвэрлэлт, ажлын байрны орчин нөхцөл, хүний нөөцийн бодлого систем буруу	Үүснэ	Бүтээмж буурна	Захиргаа, хүний нөөц
3	2025	Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний журмын хэрэгжилтийг хангах	Ажлын байрны чиг үүрэг, давхцалгүй, уялдаатай бүтцийг бий болгох	Ажлын байрны шинжилгээ хийх, дахин инженерчлэх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Процессын эрсдэл	Шаардлагагүй орон тоо нэмэгдсэнээр тогтмол зардал өсөх	Ажлын ачааллын бодит судалгаа хийгдээгүй, үүрэг хариуцлага давхацсан	Санхүүгийн үр дагавар	Ажлын байрны тогтворгүй байдал, нэмэлт зардал	Захиргаа, хүний нөөц
4	2025	Санхүүгийн үр ашиг нэмэгдүүлэх	Ашигт ажиллагаанд суурилсан урамшууллын загвар боловсруулах	Үр дүнд суурилсан үйл ажиллагаа явуулах	Санхүүгийн_эрсдэл	Үйл ажиллагааны санхүүгийн эрсдэл	Зардлын өсөлт	Инфляц, зардлын өсөлт	Орлого, зардлын буруу тооцоолол	Төсвийн тодотгол хийх	Санхүү бүртгэлийн хэлтэс
5	2025	Цалин ба урамшууллыг ашигт ажиллагаатай уялдуулах	Хөдөлмөрийн бүтээмж нэмэгдүүлэх, ажилтнуудын нийгмийн асуудал шийдвэрлэх	Зөв төлөвлөлт, сайн засаглал	Стратегийн_эрсдэл	Зохицуулалтын ба хууль эрх зүйн эрсдэл	Ажиллах хүчний тогтворгүй байдал	Төрийн компанийн өмчит бодлого, шийдвэр	Үүснэ	Ажилгүйдэл бий болно	Дотоод хяналтын алба

6	2025	Баримт бичгийн бүрэн бүтэн байдал хангах	Бичиг хэргийн бүрдлийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу хөтөлж, архивын бүрдүүлэх	Албан бичгийн загвар, стандарт мөрдүүлэх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Процессын эрсдэл	Албан бичиг стандартгүй, буруу форматтай гарах	Загвар мөрддөггүй, хяналтгүй	Үүснэ	мэдээлэл ойлгомжгүй болох , цаг хугацаа алдах	Захиргаа, хүний нөөц
7	2025	Мэдээллийн аюулгүй байдал хангах	Дотоод мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах	Аюулгүй байдлын бодлого, журмыг хэрэгжүүлэх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Нэр хүндийн эрсдэл	Гаднын халдлага, вирус	Сүлжээний хамгаалалт сул, firewall, antivirus шинэчлэгдээгүй	Сэргээн засварлах зардал өндөр	Мэдээлэл алдагдах, систем доголдох	МТ-ийн алба
8	2025	Ил тод байдал, нээлттэй байдлыг хангах	Компанийн үйл ажиллагааг олон нийтэд үнэн зөв мэдээлэх	Мэдээлэл бэлтгэх, олон нийтэд түгээх	Зах_зээлийн_эрсдэл	Өрсөлдөөний эрсдэл	Буруу, шалгагдаагүй, алдаатай мэдээлэл түгээх	Мэдээллийн эх сурвалж баталгаажуулаагүй, хяналт сул	Засварлах, залруулах зардал	Нэр хүнд унах, олон нийтийн итгэл буурах	Олон нийтийн харилцах
9	2025	Компанийн эрх ашгийг хамгаалах	Гэрээ, хэлцлийн хэрэгжилт	Гэрээг сайжруулан биелэлтийг тогтмол хянах	Үйл_ажиллагааны_эрсдэл	Хууль эрх зүйн ба нийцлийн эрсдэл	Гэрээний үүрэг хугацаандаа биелэхгүй	Гэрээний биелэлт хянах арга механизм , процесс сул	Торгууль, алдагдсан боломжийн зардал	Ажил зогсох, маргаан үүсэх	Хуулийн хэлтэс
10	2025	Үр ашигтай зөв төлөвлөн худалдан авалт хийх	Зөв төлөвлөлт, уялдаа холбоо	Хэрэгцээ шаардлагадаа уялдуулан судалгаа хийх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Процессын эрсдэл	Хэрэгцээ, тоо хэмжээ буруу төлөвлөгдөх	Мэдээлэл дутуу, ирсэн хүсэлт хоцрох	Илүү зардал гарах , хэт их шаардлагагүй нөөц үүсэх	Төсөв үр ашиггүй зарцуулагдах	ХА
11	2025	Аюултай хог хаягдлын стандарт мөрдөх	Түр хадгалах, устгах нөхцөл бүрдүүлэх	Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж байгуулах	БОНЗ_эрсдэл	Байгаль орчны бохирдлын эрсдэл	Аюулгүй байдлын эрсдэл	Аюултай хог хаягдал алдагдах, асгарах	Зориулалтын агуулах дутмаг	Байгал орчин , Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй	ХАБЭА, БО алба
12	2025	Хууль дүрэм журмын дагуу худалдан авалт хийх	Хууль журмын хэрэгжилт	Одоо мөрдөгдөж байгаа хууль, журам хэрэгжүүлэх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Процессын эрсдэл	Шинэчилсэн тендерийн хууль, журмыг дагаж мөрдөөгүй	Сургалтгүй, мэдээлэлгүй	Аудитын акт, торгууль	Хууль зөрчсөнөөр борлуулалт/үйл ажиллагаа доголдох	ХА
13	2025	Шууд худалдан авалт	Ил тод шударга худалдан авалт	Шууд худалдан авалтын үндэслэл гаргаж өгөх	Санхүүгийн_эрсдэл	Үйл ажиллагааны санхүүгийн эрсдэл	Шууд худалдан авалт хуулиас гадуур байх	Хууль дүрмийн мэдлэг дутуу	Торгууль , шийтгэл аудитын акт	Гэрээ хүчингүй болох	ХА
14	2025	Борлуулалтын орлого өсгөх	Жилийн борлуулалтын төлөвлөгөөг зөв боловсруулах	Борлуулалтын урьдчилсан таамаг тооцоо гаргах	Зах_зээлийн_эрсдэл	Худалдааны болон тарифын эрсдэл	Борлуулалтын төлөвлөгөө нь хэт өндөр эсвэл хэт бага байх	Борлуулалтын түүх мэдээ дутуу, зах зээлийн судалгаа сул	Орлогын хүлээлт биелэхгүй	Төлөвлөгөө гүйцэтгэл хангалтгүй , Бизнесийн зорилт биелэхгүй	БХ
15	2025	Тооцоо судалгааны үндэслэл, зөв төлөвлөлт	Зах зээлийн судалгаа, шинжилгээ	Судалгаа анализ хийх	Стратегийн_эрсдэл	Эдийн засгийн эрсдэл	Зах зээлийн эрэлт буруу тодорхойлолт	Судалгаа хийсэн дутуу	Ашиг олох боломж алдагдах	Борлуулалт буурах, зардал өсөх	БХ
16	2005	Борлуулалтын гэрээний үнэ, хэрэгжилт	Ашигт малтмал, баяжмалын үнэ зөв тогтоох	Үнийн тооцоо , тооцоолол хийх аргачлал боловсруулах	Зах_зээлийн_эрсдэл	Үнийн эрсдэл	Гэрээний үнэ өртөгт суурилаагүй	Зах зээлийн судалгаа дутуу, өртгийн тооцоо буруу	Ашиг алдагдал буурах алдагдал хүлээх	Гэрээ ашиггүй болох, зардал нэмэгдэх	БХ

17	2025	Тогтвортой хөгжил, байгаль орчны хариуцлагыг сайжруулах	Олон Улсын ISO 14001 стандартыг нэвтрүүлэх	ISO 14001 нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх	Стратегийн_эрсдэл	Стратегийн төлөвлөлтийн эрсдэл	Компанийн засаглал, удирдлагын манлайлал, оролцоогүй байдал	Удирдлагын бага, оролцоо шийдвэр удаашрах	Зөвлөх үйлчилгээ, аудитын зардал үр ашиггүй болох	Төсөл зогсох, стандарт нэвтрэхгүй үлдэх	Геологи уул уурхайн хэлтэс
18	2025	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо сайжруулах	Олон Улсын ISO 45001 стандартыг нэвтрүүлэх	ISO 45001 нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх	Стратегийн_эрсдэл	Стратегийн төлөвлөлтийн эрсдэл	Компанийн засаглал, удирдлагын манлайлал, оролцоогүй байдал	Удирдлагын бага, оролцоо шийдвэр удаашрах	Зөвлөх үйлчилгээ, аудитын зардал үр ашиггүй болох	Төсөл зогсох, стандарт нэвтрэхгүй үлдэх	ҮТГ ХАБЭА
19	2025	Үйлдвэрлэлийн осол, хордлого	Үйлдвэрлэлийн осол гэмтэл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Ажлын эрсдэлийн үнэлгээ хийх	Үйл_ажиллагааны_эрсдэл	ХАБЭА эрсдэл	Ажилтан үйлдвэрлэлийн осолд өртөх	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй хяналт сул	Эмчилгээний зардал, нөхөн төлбөр	Биеийн гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдах	ҮТГ ХАБЭА
20	2025	Байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх	Хүрээлэн буй орчны судалгаа	БОНЗ_эрсдэл	Байгаль орчны бохирдлын эрсдэл	Үүсмэл ордын ашиглалт болон хаягдлыг буруу хадгалснаас хөрс бохирдох	Ашиглалтын үйл ажиллагаа болон хаягдлын менежмент сул	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсох, торгууль төлөх	Хөрсөнд урт хугацааны бохирдол	ҮТГ ХАБЭА
21	2025	Усны нөөцийг хамгаалах	Усны хэрэглээг оновчтой болгох	Усны зарцуулалтын хяналт	БОНЗ_эрсдэл	Нөөцийн хомсдолын эрсдэл	Усны нөөц багасах	Усны хяналтгүй, гамгүй хэрэглээ	Шинэ худаг гаргах	Усны нөөцгүй болох	ҮТГ ХАБЭА
22	2025	Байгалын нөхөн сэргээлт, хаалтын менежмент	Хаалтын менежмент	Боловсруулсан төлөвлөгөөний дагуу төсөв хөрөнгө батлуулах	Стратегийн_эрсдэл	Эдийн засгийн эрсдэл	Төсөв төлөвлөгөө хэрэгжихгүй байх, санхүүжилт олгогдохгүй	Төлөвлөгөө хэрэгжихгүй	Торгууль	Байгаль орчин сэргээгдэхгүй	ТСГ
23	2025	Байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн болон ногоон байгууламж нэмэгдүүлэх	Суулгац тарих нийлүүлэх	БОНЗ_эрсдэл	Удирдлагын эрсдэл	Гэрээ хэрэгжихгүй, үр дүнгүй болох	Усалгаа, арчилгаа дутуу. Чанаргүй суулгац	Дахин тарих зардал нэмэгдэнэ	Төсөл амжилтгүй болох	ТСГ
24	2025	Шинэ төслүүдийг эхлүүлэх, хэрэгжүүлэх	ТЭЗҮ	Судалгаа тооцоолол хийх	Стратегийн_эрсдэл	Технологийн эрсдэл	Тооцоолол буруу байх	Тооцоо судалгаа үнэн зөв бодитой хийх	Төсөв, төлөвлөгөө дахин боловсруулах, хугацаа алдах	Төсөл төлөвлөлт буруу	Төсөл
25	2025	Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх	Төслийн шинжилгээ хийх	Хөрөнгө оруулалтын өгөөж тооцох	Санхүүгийн_эрсдэл	Үйл ажиллагааны санхүүгийн эрсдэл	ROI буруу тооцох/Хөрөнгө оруулалтын өгөөж /	Валютын ханш, түүхий эдийн үнэ өөрчлөгдөх	Хөрөнгө санхүүгийн хохирол	Хөрөнгө оруулалт ашиггүй болох	Төсөл
26	2025	Шинэ төслүүдийн байгаль орчны нөлөөлөл	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ боловсруулах	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний дүгнэлт	БОНЗ_эрсдэл	Байгаль орчны бохирдлын эрсдэл	Экологийн эрсдэл тооцоо хийгдэхгүй байх	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хангалтгүй	Нөхөн сэргээлтийн нэмэлт зардал	Зөвшөөрөл хойшлох, төсөл зогсох	ТСГ

27	2025	Аюулгүй ажиллагааг хангах	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал	Техникийн үзлэг хийх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Чанарын эрсдэл	Машин техник эвдрэх	Үзлэг үйлчилгээ тогтмол бус	Засварын зардал нэмэгдэх	Ажил тасалдах	Дэд бүтэц
28	2025	Машин механизм бүртгэл	Ашигладаггүй машин механизм ангилах , актлах	Бүртгэл тооллого	Үйл_ажиллагааны_эрсдэл	ХАБЭА эрсдэл	Ашигладаггүй машин механизмд зарцуулах зардал	Шаардлагагүй машин механизмд зарцуулах зардал	Мөнгө санхүүгийн зардал	Байгууллагын зардал өсөх	Дэд бүтэц
29	2025	Замын хөдөлгөөний аюулгүй байдал	Осол аваараас сэргийлэх	Жолоочийн хяналт	Үйл_ажиллагааны_эрсдэл	ХАБЭА эрсдэл	Замын түгжрэл, халтиргаа, жолоочийн алдаа	Хурд хэтрүүлэх, ядарсан жолооч	Хохирол, нөхөн төлбөр	Хүнд гэмтэл	ХАБЭА
30	2025	Ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх	Хайгуулын зардлыг оновчтой байлгах	Өрөмдлөгийн нарийвчилсан хайгуул	Санхүүгийн_эрсдэл	Үйл ажиллагааны санхүүгийн эрсдэл	Хайгуулын зардал төлөвлөснөөс хэтрэх	Түлш, цалин хээрийн нэмэгдэл, ажил гүйцэтгэж байгаа компани төлөх зардал өсөх	Төсөв хэтрэх	Санхүүгийн төлөвлөгөө алдагдах	ТСГ
31	2025	Хууль, ил тод байдлыг хангах	Шилэн дансны тайлагналын хугацааг баримтлах	Орлого, зарлагын мэдээлэл нийтлэх	Үйл_ажиллагааны_эрсдэл	Хууль эрх зүйн ба нийцлийн эрсдэл	Мэдээллийг хугацаанд нь нийтлээгүй	Ашиг сонирхлын зөрчил , нуун дарагдуулах	Үүснэ	Хууль зөрчсөнд тооцогдох, торгууль	Санхүү бүртгэлийн хэлтэс
32	2023	"Эрдэнэс 1 бонд"-ын өрийг Салхит төслөөс санхүүжүүлэх боломжгүй, хуулиар хүлээсэн үүрэг хангагдахгүй байх	Монгол улсын хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах	Хууль тогтоомжийн хүрээнд үүссэн нөхцөл байдалд шинжилгээ хийж холбогдох байгууллагуудаас шийдвэр гаргуулах	Стратегийн_эрсдэл	Зохицуулалтын ба хууль эрх зүйн эрсдэл	компанийн нэр хүнд буурах	ТЭЗҮ буруу, тооцоолол бүрэн хийгдээгүй	Дахин төлөвлөх, тооцоолох, төсөв нэмэгдэх	Компанийн үйл ажиллагаа зогсох, санхүүгийн чадамжгүй болох	Захиргаа, удирдлагын газар

Эрсдэлийн үнэлгээ

№	Хариуцах газар	Эрсдэлийн ангилал	Эрсдэл	Магадлал		Нөлөөлөл		Эрсдэлийн түвшин	
								Түвшин	Тоон утгаар
1	2	3	4	5	6	7	8	9	10
Дугаар	Хариуцах газар, нэгж	Хамаарах ангилал	Учирч болзошгүй эрсдэл	Тайлбар	Тоон утгаар	Эрсдэл бодитоор тулгарсны улмаас учирч болох хүлээгдэж буй үр нөлөө	Тоон утгаар 1-5	Бага	1-5
				/Эрсдэлт тохиолдох давтамж/	1-5			Дунд	6-10
								Өндөр	12-25
1	Дотоод хяналтын алба	Үйл_ажиллагааны_эрсдэл	Өртөг, зардал буурахгүй, өгөөж нэмэгдэхгүй байх	Төлөвлөлт, тооцооллын алдаанаас үйлдвэрлэлийн өртөг буурахгүй, хөрөнгийн өгөөж нэмэгдэхгүй байх	3	Орлого тасалдах, төслийн үйл ажиллагаа зогсох	3	Дунд	9
2	Захиргаа, хүний нөөц	Үйл_ажиллагааны_эрсдэл	Ажиллах хүчний дутагдал	Ажлын ачаалал тэгш бус , нийгмийн асуудал шийдвэрлэлт, ажлын байрны орчин нөхцөл, хүний нөөцийн бодлого систем буруу	4	Бүтээмж буурна	3	Өндөр	12
3	Захиргаа, хүний нөөц	Санхүүгийн_эрсдэл	Шаардлагагүй орон тоо нэмэгдсэнээр тогтмол зардал өсөх	Ажлын ачааллын бодит судалгаа хийгдээгүй,үүрэг хариуцлага давхацсан	4	Цалингийн зардал өсөх, ашиг буурах	4	Өндөр	16
4	Санхүү бүртгэлийн хэлтэс	Санхүүгийн_эрсдэл	Зардлын өсөх	Инфляц, зардлын өсөлт	2	Төсвийн тодотгол хийх	5	Дунд	10
5	Дотоод хяналтын алба	Стратегийн_эрсдэл	Ажиллах хүчний тогтворгүй байдал	Төрийн өмчит компанийн бодлого, шийдвэр	1	Ажилгүйдэл бий болно	3	Бага	3
6	Захиргаа, хүний нөөц	Үйл_ажиллагааны_эрсдэл	Албан бичиг стандартгүй, буруу форматтай гарах	Загвар мөрддөггүй, хяналтгүй	2	мэдээлэл ойлгомжгүй болох , цаг хугацаа алдах	3	Дунд	6
7	МТ-ийн алба	Үйл_ажиллагааны_эрсдэл	Гаднын халдлага, вирус	Сүлжээний хамгаалалт сул, firewall, antivirus шинэчлэгдээгүй	2	Мэдээлэл алдагдах, систем доголдох	3	Дунд	6
8	Олон нийтийн харилцах	Зах_зээлийн_эрсдэл	Буруу, шалгагдаагүй, алдаатай мэдээлэл түгээх	Мэдээллийн эх сурвалж баталгаажуулаагүй, хяналт сул	3	Нэр хүнд унах, олон нийтийн итгэл буурах	3	Дунд	9
9	Хуулийн хэлтэс	Үйл_ажиллагааны_эрсдэл	Гэрээний үүрэг хугацаандаа биелэхгүй	Гэрээний биелэлт хянах арга механизм, процесс сул	2	Ажил зогсох, маргаан үүсэх	3	Дунд	6
10	ХА	Үйл_ажиллагааны_эрсдэл	Хэрэгцээ, тоо хэмжээ буруу төлөвлөгдөх	Мэдээлэл дутуу, хэлтсүүдээс ирсэн хүсэлт хоцрох	3	Төсөв үр ашиггүй зарцуулагдах	4	Өндөр	12
11	ХАБЭА, БО нэгж	БОНЗ_эрсдэл	Аюулгүй байдлын эрсдэл	Аюултай хог хаягдал алдагдах, асгарах	2	Байгал орчин , Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй	2	Бага	4
12	ХА	Үйл_ажиллагааны_эрсдэл	Шинэчилсэн тендерийн хууль, журмыг дагаж мөрдөөгүй	Сургалтгүй, мэдээлэлгүй	1	Хууль зөрчсөнөөр борлуулалт/үйл ажиллагаа доголдох	3	Бага	3
13	ХА	Санхүүгийн_эрсдэл	Шууд худалдан авалт хуулиас гадуур байх	Хууль дүрмийн мэдлэг дутуу	3	Гэрээ хүчингүй болох	5	Өндөр	15
14	БХ	Зах_зээлийн_эрсдэл	Борлуулалтын төлөвлөгөө нь хэт өндөр эсвэл хэт бага байх	Борлуулалтын түүх мэдээ дутуу, зах зээлийн судалгаа сул	2	Төлөвлөгөө гүйцэтгэл хангалтгүй , Бизнесийн зорилт биелэхгүй	4	Дунд	8
15	БХ	Стратегийн_эрсдэл	Зах зээлийн эрэлт буруу тодорхойлолт	Судалгаа дутуу хийсэн	1	Борлуулалт буурах, зардал өсөх	4	Бага	4
16	БХ	Зах_зээлийн_эрсдэл	Гэрээний үнэ өртөгт суурилаагүй	Зах зээлийн судалгаа дутуу, өртгийн тооцоо буруу	3	Гэрээ ашиггүй болох, зардал нэмэгдэх	3	Дунд	9
17	Геологи уул уурхайн хэлтэс	Стратегийн_эрсдэл	Компанийн засаглал, удирдлагын манлайлал, оролцоогүй байдал	Удирдлагын оролцоо бага, шийдвэр удаашрах	2	Төсөл зогсох, стандарт нэвтрэхгүй үлдэх	4	Дунд	8
18	ҮТГ ХАБЭА	Стратегийн_эрсдэл	Компанийн засаглал, удирдлагын манлайлал, оролцоогүй байдал	Удирдлагын оролцоо бага, шийдвэр удаашрах	4	Төсөл зогсох, стандарт нэвтрэхгүй үлдэх	5	Өндөр	20

19	ҮТГ ХАБЭА	Үйл_ажиллагааны_эрсдэл	Ажилтан үйлдвэрлэлийн осолд өртөх	Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй хяналт сул	2	Биеийн гэмтэл, хөдөлмөрийн чадвар алдах	3	Дунд	6
20	ҮТГ ХАБЭА	БОНЗ_эрсдэл	Үүсмэл ордын ашиглалт болон хаягдлыг буруу хадгалснаас хөрс бохирдох	Ашиглалтын үйл ажиллагаа болон хаягдлын менежмент сул	3	Хөрсөнд урт хугацааны бохирдол	2	Дунд	6
21	ҮТГ ХАБЭА	БОНЗ_эрсдэл	Усны нөөц багасах	Усны хяналтгүй, гамгүй хэрэглээ	3	Усны нөөцгүй болох	5	Өндөр	15
22	ТСГ	Стратегийн_эрсдэл	Төсөв төлөвлөгөө хэрэгжихгүй байх, санхүүжилт олгогдохгүй	Төлөвлөгөө хэрэгжихгүй	2	Байгаль орчин сэргээгдэхгүй	4	Дунд	8
23	ТСГ	БОНЗ_эрсдэл	Гэрээ хэрэгжихгүй, үр дүнгүй болох	Усалгаа , арчилгаа дутуу. Чанаргүй суулгац	1	Төсөл амжилтгүй болох	4	Бага	4
24	Төсөл	Стратегийн_эрсдэл	Тооцоолол буруу байх	Тооцоо судалгаа үнэн зөв бодитой хийх	2	Төсөл төлөвлөлт буруу	3	Дунд	6
25	Төсөл	Санхүүгийн_эрсдэл	ROI буруу тооцох/Хөрөнгө оруулалтын өгөөж /	Валютын ханш, түүхий эдийн үнэ өөрчлөгдөх	2	Хөрөнгө оруулалт ашиггүй болох	4	Дунд	8
26	ТСГ	БОНЗ_эрсдэл	Экологийн эрсдэл тооцоо хийгдэхгүй байх	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хангалтгүй	3	Зөвшөөрөл хойшлох, төсөл зогсох	3	Дунд	9
27	Дэд бүтэц	Үйл_ажиллагааны_эрсдэл	Машин техник эвдрэх	Үзлэг үйлчилгээ тогтмол бус	2	Ажил тасалдах	2	Бага	4
28	Дэд бүтэц	Үйл_ажиллагааны_эрсдэл	Ашигладаггүй машин механизмд зарцуулах зардал	Шаардлагагүй машин механизмд зарцуулах зардал	3	Байгууллагын зардал өсөх	2	Дунд	6
29	ХАБЭА	Үйл_ажиллагааны_эрсдэл	Замын түгжрэл, халтиргаа, жолоочийн алдаа	Хурд хэтрүүлэх, ядарсан жолооч	3	Хүнд гэмтэл	2	Дунд	6
30	ТСГ	Санхүүгийн_эрсдэл	Хайгуулын зардал төлөвлөснөөс хэтрэх	Түлш , цалин хээрийн нэмэгдэл, ажил гүйцэтгэж байгаа компани төлөх зардал өсөх	4	Санхүүгийн төлөвлөгөө алдагдах	3	Өндөр	12
31	Санхүү бүртгэлийн хэлтэс	Үйл_ажиллагааны_эрсдэл	Мэдээллийг хугацаанд нь нийтлээгүй	Ашиг сонирхлын зөрчил , нуун дарагдуулах	4	Хууль зөрчсөнд тооцогдох, торгууль	2	Дунд	8
32	Захиргаа, удирдлагын газар	Стратегийн_эрсдэл	Компанийн нэр хүнд буурах	ТЭЗҮ буруу, тооцоолол бүрэн хийгдээгүй	3	Компанийн үйл ажиллагаа зогсох, санхүүгийн чадамжгүй болох	4	Өндөр	12

Эрсдэлийн хариу арга хэмжээний төлөвлөгөө

№	Эрсдэл	Эрсдэлийн түвшин		Эрсдэлийн удирдлагын төрөл	Хариу арга хэмжээ	Хийгдэх ажлууд	Эрсдэл хариуцагч	Хийгдэх ажлыг гүйцэтгэх хугацаа /улирлаар сонгоно/	Шаардагдах нөөц	Эрсдэлийн түвшин
1	2	3		4	5	6	7	8	9	10
Дугаар	Тодорхойлсон эрсдэл	Бага	1-5	Удирдаж болохуйц, стратегийн, гадаад хүчин зүйлийн	Эрсдэлийн удирдлагын арга хэлбэр	Тухайн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд хийгдэх ажлууд	Хийгдэх ажлыг хариуцаж хийх газар, нэгж	I-IV	Төсөв, хүний нөөц зэрэг бусад нөөц шаардлагатай нөөц	Хариу арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх эрсдэлийн доод түвшин
		Дунд	6-10							
		Өндөр	12-25							
1	Өртөг, зардал буурахгүй, өгөөж нэмэгдэхгүй байх		9	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Үйлдвэрлэлийн өртгийг тодорхой хувиар бууруулах, ерөнхий зардлын орлого дахь хувийг бууруулах, ашигт ажиллагааны түвшнийг 2025 оны гүйцэтгэлээс тодорхой хувиар өсгөсөн байна	Удирдлагын баг	I-IV	Нөөц шаардахгүй	Бууруулах
2	Ажиллах хүчний дутагдал		12	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Хүний нөөц бүрдүүлэлт, тогтвортой ажиллах ажлын нөхцөл бүрдүүлэх	Хүний нөөцийн хэлтэс	I-IV	Санхүү, хүний нөөц шаардана	Бага
3	Шаардлагагүй орон тоо нэмэгдсэнээр тогтмол зардал өсөх		16	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Ажлын байрны шинжилгээ хийх, дахин инженерчлэх	Удирдлагын баг	I	Нөөц шаардахгүй	Бууруулах
4	Зардлын өсөлт		10	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Үр дүнд суурилсан үйл ажиллагаа явуулах	Удирдлагын баг	I-IV	Нөөц шаардахгүй	Бууруулах
5	Ажиллах хүчний тогтворгүй байдал		3	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Зөв төлөвлөлт, сайн засаглал	Захиргаа удирдлагын газар	I-IV	Нөөц шаардахгүй	Арилгах
6	Албан бичиг стандартгүй, буруу форматтай гарах		6	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Албан бичгийн загвар, стандарт мөрдүүлэх	Захиргаа удирдлагын газар	I	Санхүүгийн нөөц шаардана	Арилгах
7	Гаднын халдлага, вирус		6	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Аюулгүй байдлын бодлого, журмыг хэрэгжүүлэх	Захиргаа удирдлагын газар	I	Санхүүгийн нөөц шаардана	Арилгах
8	Буруу, шалгагдаагүй, алдаатай мэдээлэл түгээх		9	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Мэдээлэл бэлтгэх, олон нийтэд түгээх	Хууль эрх зүйн хэлтэс	II	Нөөц шаардахгүй	Арилгах
9	Гэрээний үүрэг хугацаандаа биелэхгүй		6	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Гэрээг сайжруулан биелэлтийг тогтмол хянах	Санхүү удирдлагын газар	I	Нөөц шаардахгүй	Бууруулах
10	Хэрэгцээ, тоо хэмжээ буруу төлөвлөгдөх		12	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Хэрэгцээ шаардлагадаа уялдуулан судалгаа хийх	Санхүү удирдлагын газар	I	Нөөц шаардахгүй	Арилгах
11	Аюулгүй байдлын эрсдэл		4	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Аюултай хог хаягдлыг түр хадгалах байгууламж байгуулах	Санхүү удирдлагын газар	III	Санхүүгийн нөөц шаардана	Бууруулах
12	Шинэчилсэн тендерийн хууль, журмыг дагаж мөрдөөгүй		3	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Одоо мөрдөгдөж байгаа хууль, журам хэрэгжүүлэх	Борлуулалтын хэлтэс	I	Нөөц шаардахгүй	Арилгах
13	Шууд худалдан авалт хуулиас гадуур байх		15	Урьдчилан сэргийлж болохуйц	Эрсдэлээс зайлсхийх, арилгах	Шууд худалдан авалтын үндэслэл гаргаж өгөх	Санхүү, удирдлагын газар	III	Нөөц шаардахгүй	Арилгах

